Шүүхийн ахмадуудын холбооны III их хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор шинэчлэн батлав.

ШҮҮХИЙН АХМАДУУДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрмээр Шүүхийн ахмадуудын холбооны үйл ажиллагааг зохицуулна.
2. Шүүхийн ахмадуудын холбоо нь ахмад шүүгч, ажилтны нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах, бүтцийн нэгжүүдээр дамжуулан гишүүддээ үйлчлэн туслах, ахмад настны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг холбооны хүрээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага /хуулийн этгээд/ мөн.
3. Холбоо нь шүүхийн тамгын газрыг түшиглэсэн бүтцийн нэгж (Салбар зөвлөл)-үүдтэй байна
4. Холбоо өөрийн онцлогийг илэрхийлсэн билэгдэл (лого, туг) тэмдэг, харилцах данс, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Хоёр: Үйл ажиллагааны үндсэн зарчим

2.1. Шүүхийн хараат бус байдлыг хүндэтгэн хамгаалж, хууль дээдлэн ажиллана.
2.2. Холбооны зохион байгуулалт нэгдмэл, үйл ажиллагаа нь нээлттэй, гишүүнчлэл нь сайн дурын байна.Гишүүддээ эрх тэгш үйлчилнэ.
2.3. Холбоо нь төрийн байгууллагын чиг үүргийг орлон гүйцэтгэхгүй, улс төрийн үйл ажиллагаа бие даан явуулахгүй.
2.4. Холбоо гишүүдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа ямагт чиглүүлнэ.

Гурав. Зорилго.

3.1. Ахмад шүүгч, ажилтныг эгнээндээ нэгтгэх, нийтлэг эрх ашгийг төлөөлөх, ахмад настны тухай хууль тогтоомжийг холбооны хүрээнд хэрэгжүүлэх, бүтцийн нэгжүүдэд зөвлөн туслах, шүүхийн хараат бус байдлыг хангаж хамгаалахад гишүүдийн оролцоог дэмжих, ахмад шүүгч, ажилтны мэдлэг, туршилгыг залуу үед дамжуулах ажлыг зохион байгуулах, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд ахмад шүүгч, ажилтны хүч, анхаарлыг чиглүүлэх, ахмад настны хөдөлмөр эрхлэлт, амьдралын чанарыг дээшлүүлэх, ахмад шүүгч, ажилтны санал, санаачилга, зөвлөмж, эрэлт хүсэлтийг нь шүүхийн болон бусад байгууллагад уламжлах, тэдний нийгмийн оролцоог үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь Шүүхийн ахмадуудын холбооны үндсэн зорилго мөн.

Дөрөв. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

4.1. Холбоо нь дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.
- 4.1.1 Ахмад настны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар шүүхийн захиргааны төв, орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах,
- 4.1.2 Шүүхийн хараат бус байдлыг хангаж, хамгаалахад ахмад шүүгч, ажилтны оролцоог хангах ажилд дэмжлэг үзүүлэх

4.1.3 Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд ахмад шүүгч, ажилтны хүч, анхаарлыг чиглүүлэх,

4.1.4 Ахмад шүүгч, ажилтны эрх ашгийг хамгаалах, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар шүүхийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, холбон зуучлах,

4.1.5 Ахмад шүүгч, ажилтны мэдлэг, туршилгыг залуу үед дамжуулах ажлыг зохион байгуулах

4.1.6 Холбооны гишүүдэд амьдралын чанарыг сайжруулахад шаардлагатай мэдээллээр хангах

4.1.7 Холбооны гишүүдийн бүтээл туурвилыг нийтийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлэх

4.1.8 Холбооны гишүүдийн дунд идэхтэй аялал, урлаг, спортын тоглолт, уралдаан тэмцээн зохион байгуулах.

4.1.9 Холбооны гишүүдийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, амралт сувилалд амруулах, ажлын байранд зуучлах ажлыг бүтцийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулах,

4.1.10 Холбооны зорилго, үйл ажиллагаагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх.

4.1.11 Холбооны дотоод, гадаад харилцааг өргөтгөх, олон улсын болон хөрш орнуудын ахмадын болон ижил төстэй байгууллага, холбоодтой ажил хэргийн холбоо тогтоож, хамтран ажиллах.

4.1.12 Холбооны гишүүдийг шагнал урамшуулалд тодорхойлох,

4.1.13 Холбооны мэдээлэл, албан хэрэг, архивыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх

Тав: Холбооны удирдлага, бүтэц, зохион байгуулалт

5.1. Холбоо дараах удирдлагын зохион байгуулалттай байна. Үүнд:

5.1.1. Их хурал,

5.1.2. Удирдах зөвлөл

5.1.3. Холбооны тэргүүн, ажлын алба

5.1.4. Хяналтын зөвлөл

5.1.5. Бүтцийн нэгж буюу Салбар зөвлөл зэргээс бүрдэнэ.

5.2. Салбар зөвлөлийг нутаг дэвсгэрийн эсхүл шүүхийн харьяаллаар нэгтгэн байгуулж болно.

5.3. Холбоо дэд хороо, мөн үйл ажиллагааны чиглэлээр хөдөлмөр эрхлэлт, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, эрүүл мэнд, аялал, спортын асуудал эрхэлсэн ажлын хэсэгтэй байж болно.

Зургаа. Их хурал

6.1. Холбооны дээд байгуулага Их хурал мөн.

6.2. Их хурал ээлжит болон ээлжит бусаар хуралдаж болно.

6.3. Их хурлыг 3 жилд 1 удаа хуралдуулна.

6.4. Ээлжит бус Их хурлыг Холбооны тэргүүний санал эсвэл Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хүсэлт гаргавал зарлан хуралдуулж болно.

6.5. Ээлжит болон ээлжит бус Их хурлыг цахимаар болон харилцаа холбооны бусад хэрэгсэл ашиглан хийж болно.

6.6. Ээлжит болон ээлжит бус Их хурлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах ажлыг Холбооны Удирдах зөвлөл, ажлын алба хариуцана.

6.7. Их хурал дор дурьдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.7.1. Холбоог өөрчлөн байгуулах, бүтэц зохион байгуулалтыг тогтоох, татан буулгах,

6.7.2. Холбооны дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах

6.7.3. Холбооны удирдах зөвлөл болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох,

6.7.4. Холбооны тэргүүнийг сонгох, чөлөөлөх,

6.7.5. Холбооны ажлын тайлан хэлэлцэх, мэдээлэл сонсох,

6.7.6. Хяналтын зөвлөлийн тайлан хэлэлцэх

6.7.7. Гишүүдийн хуримтлалын хэмжээг тогтоох, өөрчлөх,

6.7.8. Дүрэмд заасан бусад бүрэн эрх болно.

6.8. Их хурал хуралдуулах тов, хэлэлцэх асуудлыг Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр тогтооно.

6.9. Их хурал нь Салбар зөвлөлийн гишүүдийн төлөөлөгчдөөс бүрдэх бөгөөд 25 болон түүнээс дээш гишүүнтэй зөвлөлөөс 2, бусад зөвлөлөөс 1 төлөөлөгчийг сонгож оролцуулна. Сонгогдсон төлөөлөгч тухайн Салбар зөвлөлийн гишүүдийг бүрэн төлөөлнө.

6.10. Их хурал нь төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хүчинтэйд тооцогдох бөгөөд бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана.

6.11. Хурал дэгээ өөрөө тогтоож, хурлын дарга, нарийн бичгийн даргыг сонгоно.

6.12. Их хурлын тогтоолд хурлын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

Долоо. Холбооны Удирдах зөвлөл.

7.1. Удирдах зөвлөл нь Холбооны тэргүүн, ажлын албаны дарга болон бусад таваас дээшгүй гишүүдээс бүрдэх бөгөөд орон тооны бус байна.

7.2. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Их хурлаас олонхийн саналаар 3 жилийн хугацаагаар сонгоно. Удирдах зөвлөлийн гишүүнийг хүндэтгэн үзэх шалтгаан, өөрийн хүсэлтээр нь Удирдах зөвлөлийн гишүүнээс Удирдах зөвлөлийн шийдвэрээр чөлөөлж, оронд нь шинэ гишүүнийг сонгож болно. Сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа бусад гишүүнийхтэй адил байна.

7.3. Удирдах зөвлөлийн хурлыг жилд дөрвөөс доошгүй удаа хуралдуулна. Ээлжит бус хурлыг шаардлагатай тохиолдолд Холбооны тэргүүний шийдвэрээр хэдийд ч зарлан хуралдуулж болно.

7.4. Удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлыг цахимаар болон харилцаа холбооны бусад хэрэгсэл ашиглан хийж болно.

7.5. Удирдах зөвлөлийн хуралд нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хурал хүчинтэйд тооцогдох бөгөөд хуралдаанд оролцогчдын олонхын саналаар шийдвэр гаргаж, тогтоол батална.

7.6. Удирдах зөвлөлийн хурлын тогтоолд Холбооны тэргүүн гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

7.7. Удирдах зөвлөл дор дурьдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.7.1. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, татан буулгах саналыг Их хуралд оруулах
7.7.2. Холбооны тухайн жилийн ажлын үндсэн чиглэл, төсвийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих.
7.7.3. Их хурлыг зарлан хуралдуулах
7.7.4. Ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх
7.7.5. Гишүүдийг шагнаж урамшуулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.
7.7.6. Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, төсвийг батлах
7.7.7. Шаардлагатай гэж үзвэл холбооны үйл ажиллагааны чиглэлээр “хороо”, “хэсэг” байгуулж болно.
7.7.8. Удирдах зөвлөлийн зарим бүрэн эрхийг холбооны Тэргүүнд шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх
7.7.9. Холбооны ажлын албаны бүтэц орон тоог батлах.
7.7.10. Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг зохицуулах, тайлан гаргуулах, нэгтгэх, Салбар зөвлөлийн тэргүүний сонсгол мэдээллийг хэлэлцүүлэх, ажлыг дүгнэх, шалгаруулах,
7.7.11. Холбооны үйл ажиллагаанд шаардлагатай заавар, журам, зөвлөмж, бүртгэлийн маягтыг /гишүүдийн, шагнал урамшлын, хуримтлалын г,м/ боловсруулж батлах
7.7.12. Удирдах зөвлөлийн гишүүд, ажлын албаны дарга, ажилтны ажил үүргийн хуваарийг батлах,
7.7.13. Дүрэмд заасан бусад бүрэн эрх.
7.7.14. Удирдах зөвлөл нь Их хурлын чөлөө цагт түүний зарим бүрэн эрх /удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, орон гарсан гишүүнийг нөхөн сонгох г.м/-ийг хэрэгжүүлж болно.

Найм. Холбооны тэргүүн.

8.1. Холбооны Тэргүүн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.Үүнд:
8.1.1. Холбоог ерөнхий удирдлага, зохион байгуулалтаар хангах,
8.1.2. Холбоог дотоод, гадаадад төлөөлж, холбооны нэрийн өмнөөс шүүхийн захиргааны төв, орон нутгийн байгуулага, төрийн ба төрийн бус байгууллагатай харилцах,
8.1.3. Удирдах зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулах, хуралдааныг даргалах
8.1.4. Холбооны үйл ажиллагааны чиглэл /төлөвлөгөө/-ийн хэрэгжилтэд хяналт тавих,
8.1.5. Удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөх, нөхөн сонгох талаар Их хуралд санал оруулах, хэлэлцүүлэх
8.1.6. Ажлын албаны даргын нэрийг дэвшүүлэх, Ажлын албаны даргатай гэрээ байгуулах, түүнд үүрэг даалгавар өгөх,
8.1.7. Холбооны мөнгө санхүүг хуримтлуулж, аривжуулах арга хэмжээг зохион байгуулах.
8.1.8. Удирдах Зөвлөлийн гишүүдийн ажил үүргийг хуваарилах,
8.1.9. Төв, орон нутгийн салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн салбар зөвлөлийн тэргүүнийг батламжлах,
8.1.10. Холбооны тэргүүн бүрэн эрхийн асуудлаар тушаал гаргана.

Ес. Ажлын алба

9.1. Ажлын алба нь Холбооны өдөр тутмын ажлыг удирдан зохион байгуулна.
9.2. Ажлын алба дарга болон орон тооны ажилтнаас бүрдэнэ.
9.3. Ажлын албаны даргад Холбооны Тэргүүн нэр дэвшүүлж, Удирдах зөвлөл томилно. Орон тооны ажилтанг Албаны дарга томино.
9.4. Ажлын албаны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
9.4.1. Холбооны жилийн ажлыг төлөвлөх, биелэлтийг зохион байгуулна.
9.4.2. Холбооны их хурал болон Удирдах зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, шийдвэрийн хэрэгжилтийг хангана.
9.4.3. Холбооны албан хэргийн бүрдлийг хангаж, архивын сан хөмрөг бүрдүүлнэ.
9.4.4. Холбооны мөнгөн хөрөнгийг Удирдах зөвлөлийн тогтоол, Холбооны тэргүүний шийдвэрийг үндэслэн захиран зарцуулна.
9.4.5. Санхүү хариуцсан ажилтан /ня-бо/-ыг гэрээгээр авч ажиллуулна. Санхүүгийн үр нөлөөтэй удирдлагыг хэрэгжүүлнэ.
9.4.6. Салбар зөвлөлүүдийн ажлын мэдээг Удирдах зөвлөлийн хуралдаанд танилцуулна.
9.4.7. Дүрэмд заасан бусад бүрэн эрх.

Арав. Холбооны салбар зөвлөл.

10.1. Холбооны салбар зөвлөлийг шүүхийн захиргааны байгууллагыг түшиглэн байгуулна.
10.2. Салбар зөвлөлийн тэргүүнийг Зөвлөлийн бүх гишүүдийн хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар 3 жилийн хугацаагаар сонгоно.
10.3. Салбар зөвлөлийг байгуулах анхны хуралдааныг шүүхийн тамгын газартай хамтран зохион байгуулна.
10.4. Салбар зөвлөлийн бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор Зөвлөлийн хуралдаан хүчинтэйд тооцогдох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэж тэмдэглэл үйлдэнэ.
10.5. Салбар зөвлөлийн хурал хийх тов, хэлэлцэх асуудлыг Салбар зөвлөлийн тэргүүний шийдвэрээр тогтооно.
10.6. Зөвлөлийн хурал дэгээ өөрөө тогтоож, хурлын дарга, нарийн бичгийн даргыг сонгоно.
10.7. Салбар зөвлөлийн хурлын тэмдэглэлд хурлын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
10.8. Холбооны салбар зөвлөлийн хурлыг жилд хоёроос доошгүй удаа зарлан хуралдуулна.
10.9. Холбооны 20-иос дээш гишүүнтэй Салбар зөвлөл нь тэргүүлэгч гишүүдтэй байж болно.
10.10. Салбар зөвлөл нь Их хурал, Удирдах зөвлөл, Холбооны тэргүүний гаргасан шийдвэр, зөвлөмжийг салбар зөвлөлийн хүрээнд зохион байгуулж, жил бүр ажлын төлөвлөгөөтэй ажиллана.
10.11. Салбар зөвлөл нь доорхи бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.11.1. Холбоо удирдах байгууллагаас гаргасан шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг Салбар зөвлөлийн хэмжээнд зохион байгуулж, жил бүр ажлын тайлан ирүүлнэ.

10.11.2. Салбар зөвлөлд хуваарилагдсан мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах жилийн төлөвлөгөө гаргаж, тамгын газрын даргаар батлуулж, үр нөлөөтэй зарцуулах ажлыг зохион байгуулах

10.11.3. Гишүүний хуримтлалыг сар бүр хурааж холбооны дансанд төвлөрүүлнэ.

10.11.4. Гишүүдийн санал хүсэлтийг нэгтгэн холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд илгээж шийдвэрлүүлнэ.

10.11.5. Гишүүдийн дэлгэрэнгүй судалгааг жил бүр шинэчлэн гаргаж, Холбооны ажлын албанд ирүүлэх ба Дүрмийн “Дөрөв”-т заасан Холбооны үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэхэд санаачлага гаргаж, идэвхтэй ажиллана.

10.11.6. Салбар зөвлөлийн тэргүүн нь баталгааны тэмдэгтэй байж болно. Тэмдгийн загварыг Удирдах зөвлөл нэг мөр батална.

Арван нэг. Хяналтын зөвлөл.

11.1. Хяналтын зөвлөл нь Холбооны дүрэм, Их хурал, Удирдах зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, хөрөнгө санхүүгийн зарцуулалт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих байгууллага мөн.

11.2. Хяналтын зөвлөл 3 гишүүнтэй байна. Гишүүдийг Холбооны Их хурлаас 3 жилийн хугацаагаар сонгоно.

11.3. Холбооны тэргүүн, Удирдах зөвлөлийн гишүүн, түүнчлэн гэрээт ажилтан Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд орохгүй.

11.4. Хяналтын Зөвлөл жилд хоёроос доошгүй удаа хуралдана.

11.5. Хяналтын Зөвлөл шаардлагатай баримт бичгийг Ажлын албанаас саадгүй гаргуулан авах эрхтэй.

11.6. Хяналтын Зөвлөл илэрсэн дутагдлыг тухай бүр Их хурал болон Удирдах зөвлөлд мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авахуулна.

11.7. Хяналтын зөвлөл эрх хэмжээнд хамаарах асуудлаар дүгнэлт гаргана.

11.8. Хяналтын зөвлөлийн ажиллах нөхцөлийг Ажлын алба бүрдүүлнэ.

Арван хоёр. Холбооны гишүүнчлэл

12.1. Холбоо гишүүнчлэлтэй байна. Холбооны дүрмийг хүлээн зөвшөөрч, үйл ажиллагаанд нь оролцохыг хүссэн тэтгэвэр тогтоолгосон шүүгч, шүүхийн захиргааны ажилтан Холбооны гишүүн байх эрхтэй. Холбооны гишүүн салбар зөвлөлд бүртгүүлснээр гишүүнчлэл баталгаажна.

12.2. Холбооны гишүүн гишүүнчлэлээс татгалзаж болно. Энэ тухай салбар зөвлөлд бичгээр хүсэлт гаргана. Мөн хуримтлалаа 1 жил төлөөгүй тохиолдолд гишүүнчлэлээс татгалзсанд тооцно.

12.3. Гишүүнчлэлээ сэргээлгэх эрх ямагт нээлттэй байна.

12.4. Холбооны гишүүн нийтлэг эрх ашгаа хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Холбооны Их хурлаас тогтоосон мөнгийг сар бүр Холбооны санд хуримтлуулна. Хуримтлалын хэмжээг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд

Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөн тогтоож, Их хуралд танилцуулж болно. Гишүүний хуримтлал төвлөрүүлэх, хөнгөлөх, чөлөөлөх журмыг Удирдах зөвлөлийн хуралдаанаар батлана.

12.5. Холбооны гишүүн дараах эрхтэй.

12.5.1. Холбооны бүх шатны удирдах байгууллагад сонгох, сонгогдох, үйл ажиллагаанд оролцох,

12.5.2. Холбооны удирдах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, холбооны гишүүдийн өмнө тулгамдсан асуудлыг хэлэлцэхэд оролцож, үзэл бодлоо илэрхийлэх,

12.5.3. Хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасны дагуу эрхээ хамгаалуулах, дэмжлэг туслалцаа хүсэх, авах,

12.3.4. Өөрийн хүсэлтээр гишүүнчлэлээс татгалзах зэрэг болно.

12.6. Холбооны гишүүн дараах үүрэгтэй байна:

12.6.1. Холбогдох хууль, холбооны дүрмийг хэрэгжүүлэх,

12.6.2. Тогтоосон журмын дагуу сар бүр хуримтлал төлөх

12.6.3. Холбооноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох

12.6.4. Холбооны санд мөнгө, хөрөнгө хандивлах, санхүүгийн чадвахыг нэмэгдүүлэхэд идэвхи санаачлага гарган оролцох

12.7. Гишүүн санал хүсэлтээ харъяа Салбар зөвлөлдөө хандаж уламжлуулна.

Арван гурав. Холбооны санхүүжилт.

13.1. Холбоо нь өөрийн мөнгөн болон бусад эд хөрөнгөтэй байна.

13.2. Холбооны эд хөрөнгө доорхи эх үүсвэрээс бүрдэнэ.

13.2.1. Иргэд, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын хандив, дэмжлэг,

13.2.2. Дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдуулан аж ахуй болон бусад үйл ажиллагаанаас олсон орлого,

13.2.3. Зээл, хадгаламжийн хүү, ахмад настны тухай хуулийн дагуу байгуулсан ахмадын сан, төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө.

13.2.4. Гадаадын болон олон улсын байгууллагын хандив, тусламж.

13.2.5. Гишүүдийн хуримтлал болон салбар зөвлөлөөс нэгдсэн арга хэмжээнд зориулан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө

13.3. Холбооны тэргүүн, ажлын албаны дарга, нягтлан бодогч нарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

13.3.1. Холбооны орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуй нэгж байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах

13.3.2. Ахмадын сангийн хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулах,

13.3.3. Сонгуулийн үйл ажиллагаанд буюу нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгөх зэрэг болно.

13.4. Холбоо хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагад санхүүгийн үйл ажиллагааны жилийн тайланг гаргаж, дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

Арван Дөрөв. Бусад асуудал

14.1. Холбоог бүх гишүүдийн хурлын шийдвэрээр болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу татан буулгаж болно.

14.2. Холбоо татан буугдсан тохиолдолд хөрөнгийг энэхүү дүрэмд заасан зорилгод нийцүүлэн бүрэн зарцуулж, тайлан гаргана.

14.3. Холбоо нь гишүүн болон бусад сонгуультны хууль бус үйл ажиллагаатай холбогдсон эд хөрөнгийн болон бусад хариуцлагыг хүлээхгүй

14.4. Холбоо нь өөрийн нэрэмжит шагналтай байж болно.

14.5. Дүрэм батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр.
Улаанбаатар хот.